ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

2026.10

СТАТИСТИК ТОЙМ

Үзүүлэлтүүд	Нэгж	Тайлант хугацаа	Өмнөх үе	Өмнөх оны мөн үе	Жилийн өсөлт
УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2026Q2	**2026Q1**	**2025Q2**	
Бодит ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр)	тэрбум төгрөг	**16,428**	6,736	15,257	7.7%
Нэрлэсэн ДНБ	тэрбум төгрөг	**51,338**	23,024	40,061	28.1%
Ажилгүйдлийн түвшин	%	**5.5%**	5.7%	4.5%	1.0
Өрхийн сарын дундаж орлого, нэрлэсэн	мянган төгрөг	**3,497**	3,496	3,305	5.8%
Өрхийн сарын дундаж зарлага, нэрлэсэн	мянган төгрөг	**3,273**	3,391	3,094	5.8%
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2026M9	**2026M8**	**2025M9**	
Гадаад секторын үзүүлэлтүүд					
Нийт экспорт	сая ам.доллар	**16,199**	14,400	10,711	51.2%
Зэс	сая ам.доллар	**7,081**	6,291	3,946	79.4%
Нүүрс	сая ам.доллар	**5,980**	5,325	3,927	52.2%
Нийт импорт	сая ам.доллар	**9,725**	8,865	8,542	13.8%
Хэрэглээ	сая ам.доллар	**2,674**	2,363	2,706	-1.2%
Хөрөнгө оруулалт	сая ам.доллар	**3,923**	3,356	3,587	9.3%
Аж үйлдвэрлэл	сая ам.доллар	**913**	793	689	32.5%
Шатахуун	сая ам.доллар	**2,197**	1,849	1,550	41.7%
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар	**6,474**	6,027	2,169	2.0x
ГВАН	сая ам.доллар	**8,897**	8,372	5,875	51.4%
Нэрлэсэн ханш (хугацааны эцэст)	Төгрөг/$	**3,596**	3,595	3,592	0.11%
Төлбөрийн тэнцэл (2026.08)	сая ам.доллар	**463**	260	-289	250%
Урсгал данс	сая ам.доллар	**236**	70	-57	514%
Санхүүгийн данс	сая ам.доллар	**150**	221	599	-74.9%
Түүхий эдийн үнэ (Primary Commodity Prices, IMF, Монголбанк)					
Зэс	$/тонн	**14,473**	14,331	9,994	43.4%
Нүүрс (хилийн)	$/тонн	**83.5**	77.6	61.4	36.0%
Алт	$/трой унц	**4,334**	4,419	3,652	18.7%
Газрын тос (брент)	$/баррел	**102.0**	88.1	67.6	50.9%
Улсын нэгдсэн төсөв					
Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	тэрбум төгрөг	**- 1,642.0**	-2,206	- 1,335	23%
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого	тэрбум төгрөг	**22,916**	20,075	20,723	10.6%
Төсвийн нийт зарлага	тэрбум төгрөг	**24,558**	22,236	22,058	11.3%
Мөнгөний бодлого					
М2 нийлүүлэлт	тэрбум төгрөг	**56,760**	54,401	43,434	30.6%
Инфляц	%	**12.9%**	12.5%	9.0%	%
Бодлогын хүү	%	**12.5%**	12.5%	12.0%	0.5%
Жигнэсэн дундаж хүү					
Төгрөгийн хадгаламжийн ЖДХ (шинээр татсан)	%	**11.76%**	11.74%	11.87%	0.00%
Валютын хадгаламжийн ЖДХ (шинээр татсан)	%	**3.21%**	4.20%	4.82%	-23.57%
Төгрөгийн зээлийн ЖДХ (шинээр олгосон)	%	**17.59%**	17.26%	17.26%	1.9%
Валютын зээлийн ЖДХ (шинээр олгосон)	%	**10.23%**	10.39%	11.21%	-8.7%

ОЛОН УЛСЫН ТОЙМ









9-р сард АНУ-ын инфляц дахин өсөв. Өнгөрсөн сард Холбооны нөөцийн банк 3 жилийн дараа анх удаа бодлогын хүүгээ 25 суурь нэгжээр нэмэгдүүлж, 3.75%-4.00%-д хүргэсэн. Инфляц 3.4%-аас 3.7%, суурь инфляц 2.4%-аас 2.6% болж өссөн байна. Тавдугаар сард оргилдоо хүрснээс хойш буурах хандлагатай байсан инфляц ийнхүү дахин өссөн нь үнийн дарамт бүрэн намжаагүйг илтгэж, ХНБ бодлогын хүүгээ дахин нэмэгдүүлж болзошгүй гэсэн хүлээлтийг хадгалж байна. **АНУ-ын 10 жилийн хугацаат Засгийн газрын бондын өгөөж 2026 оны турш өсөж, 9-р сард 5.3%-д хүрэв.** Энэхүү өсөлтөд өндөр инфляцаас шалтгаалан ХНБ бодлогын хүүгээ өндөр түвшинд хадгалах хүлээлт нэмэгдсэн нь нөлөөллөв. Түүнчлэн төсвийн алдагдал нэмэгдсэнтэй холбоотойгоор Засгийн газрын бондын нийлүүлэлт өсөж, хөрөнгө оруулагчид илүү өндөр өгөөж шаардах болсон нь өгөөжийн өсөлтийг дэмжсэн байна. Үүнээс гадна урт хугацаат өгөөж нэмэгдсэн нь санхүүжилтийн өртгийг өсгөж, эдийн засгийн идэвхжилд сааруулах нөлөө үзүүлж болзошгүй байна.

Хятадын хэрэглээний үнийн индекс (CPI) 9-р сард ердөө 0.9%-иар өссөн нь дотоодын эрэлт сул хэвээр байгааг харуулж байна. Харин PPI 4 жилийн дараа анх удаа 5.0%-д хүрсэн нь үйлдвэрлэлийн бүтэц өндөр технологи, өндөр нэмүү өртөг шингэсэн салбарууд руу шилжиж буйн илрэл байж болох юм. ОУВС Хятадыг экспортод бус хэрэглээ, өрхийн эрэлтэд тулгуурласан өсөлт рүү шилжих шаардлагатайг онцолж байна.

Мөн юанийн бодит үйлчилж буй ханш (REER) 91.9-д хүрч, ам.долларын эсрэг ханш 6.7 хүртэл чангарсан нь экспортын үнийн өрсөлдөх чадварт дарамт учруулах хүчин зүйл болж байна. Гэсэн хэдий ч экспортын өсөлт өндөр хэвээр байгаа нь Хятадын өрсөлдөх чадвар ханшийн давуу талаас илүүтэй өндөр технологи, өндөр нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнд түшиглэх болсныг харуулж байна.

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ









2026 оны эхний 10 сарын байдлаар түүхий эдийн зах зээлүүд ялгаатай чиглэлд хөдөлсөн байна. Ойрхи Дорнод дахь геополитикийн хурцадмал байдал, АНУ-Ираны мөргөлдөөнөөс үүдэлтэй эрчим хүчний нийлүүлэлтийн эрсдэл нь газрын тосны зах зээлд хамгийн хүчтэй нөлөөлсөн хэвээр байна. Үүний үр дүнд WTI газрын тосны үнэ оны эхэнд 60 орчим ам.доллар/баррель байсан бол 10-р сарын байдлаар 103.4 ам.доллар/баррельд хүрч, оны эхнээс ойролцоогоор 75%-иар өссөн байна.

Харин алтны үнэ эсрэг чиглэлд хөдөлжээ. Оны эхний хагаст геополитикийн эрсдэл болон аюулгүй хөрөнгийн эрэлтээс шалтгаалан алтны үнэ түүхэн өндөр түвшинд хүрсэн боловч оны хоёрдугаар хагаст аажмаар буурсан байна. 10-р сарын байдлаар алтны үнэ 4,030 ам.доллар/унц хүрсэн нь жилийн эхний түвшнээс ойролцоогоор 7%-иар буурсан үзүүлэлт юм. АНУ-ын эдийн засгийн харьцангуй тогтвортой өсөлт, өндөр бодлогын хүүгийн орчин, ам.долларын хүчтэй байдал нь алтны өсөлтийг хязгаарласан байна.

Нүүрсний үнэ 10-р сард өндөр түвшинд хадгалагдаж 150 ам.доллар/тоннын орчимд байна. Үүнд Ойрхи Дорнод дахь геополитикийн хурцадмал байдал, эрчим хүчний зах зээл дэх нийлүүлэлтийн эрсдэл, мөн нүүрсийг орлох эрчим хүчний эх үүсвэрүүдийн өртөг нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Үүний үр дүнд нүүрсний зах зээлд эрэлт харьцангуй дэмжигдэж, үнэ өндөр түвшинд тогтвортой хадгалагдсан байна.

Дэлхийн хэмжээнд дата төв, хиймэл оюун ухааны дэд бүтэц, сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалт үргэлжилснээр зэсийн эрэлт өндөр хэвээр хадгалагдсан байна. Үүний зэрэгцээ томоохон олборлогч орнуудын нийлүүлэлтийн хүндрэлүүд зах зээлд нөлөөлснөөр зэсийн үнэ оны эхний түвшнээс өсөж, 10-р сарын байдлаар 14,475 ам.доллар/тоннд хүрсэн байна. Энэ нь оны эхэн үеийн түвшнээс ойролцоогоор 16%-иар өндөр үзүүлэлт болж байна.

ДОТООД ЭДИЙН ЗАСАГ:
МАКРО ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Эдийн засгийн өсөлт, нэрлэсэн ДНБ



Инфляц ба Бодлогын хүү



Банкны зээлийн өсөлтийн хувь



Мөнгөний үзүүлэлтүүд, их наяд төгрөг



2026 оны 8-р сарын байдлаар эдийн засгийн өсөлт 7.3%-тай гарч өмнөх саруудаас бага зэрэг саарлаа. Өсөлтийн тал орчим хэсгийг уул уурхайн салбарын өсөлт бий болгосон буюу 3.4 нэгж хувийг эзэлсэн бол хөдөө аж ахуйн салбар 1.4 нэгж хувиар удаалжээ. Уул уурхайн салбарын оролцоо өмнөх сараас 0.3 нэгж хувиар суларсан ба үүнийг даган тээврийн салбарын оролцоо 0.8 нэгж хувиас 0.7 болжээ. Худалдааны салбарын хувьд оны туршид идэвхжил сул байгаа ба 8-р сарын байдлаар өнгөрсөн оноос 0.2 хувь өсөж өсөлтөд 0 нэгж хувийн оролцоог бий болгожээ.

2026 оны 9 дүгээр сарын байдлаар инфляц 12.9%-д хүрч, өмнөх сарын 12.5%-ийн түвшнээс өссөн байна. Инфляцын өсөлтийн гол эх үүсвэр нь махны үнийн өндөр өсөлт хэвээр байгаа бөгөөд үхрийн махны үнэ өмнөх оны мөн үеэс 48.4%-иар, хонь, ямааны махны үнэ 58.5%-иар өссөн байна. Мөн нийт инфляцын 2.1 нэгж хувийг шатахууны үнийн өсөлт бүрдүүлсэн бөгөөд АИ-92 бензиний үнэ өмнөх оны мөн үеэс 17.4%-иар өсжээ. Үүнээс гадна импортын барааны үнийн өсөлт нийт инфляцын 4.1 нэгж хувь буюу 32.1%-ийг тайлбарлаж байгаагаас 2.0 нэгж хувь нь шатахуунаас бусад импортын барааны өсөлтөөр тайлбарлагдаж байна.

2026 оны 9 дүгээр сарын байдлаар нийт зээлийн жилийн өсөлт 15.4%-д хүрч, өмнөх сарын 14.3%-ийн түвшнээс өссөн байна. Нийт зээлийн өсөлтийг бизнесийн зээл голлон дэмжсэн бөгөөд бизнесийн зээлийн жилийн өсөлт 19.5%-д хүрчээ. Харин хэрэглээний зээлийн өсөлт сул хэвээр буюу 5.2%-д байна. Нөгөө талаас нийт зээлийн 5.2%-ийг чанаргүй зээл бүрдүүлж байгаа бол хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь 2.3% болж, нийт дүн нь өмнөх оны мөн үеэс 39.0%-иар буурсан нь зээлийн чанарт эерэг дохио болж байна.

Мөнгөний нийлүүлэлт 56.8 их наядад хүрсэн бол хадгаламж 62.5 их наяд, зээл 49.3 их наядад хүрлээ. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 9-р сард 30.6 хувьд хүрээд байгаа нь голлон зээлийн өсөлт болон гадаад цэвэр активын өсөлттэй холбоотой хэвээр байна. Тодруулбал, зээлийн өсөлтийн нөлөө харьцангуй тогтвортой хадгалагдаж байгаа бол 2026 он гарснаас хойш экспортын өсөлт эрчимжсэн нь ГЦА-аар дамжуулан мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг дэмжиж байгаа юм.

ДОТООД ЭДИЙН ЗАСАГ:
ГАДААД ХУДАЛДАА









2026 оны эхний есөн сарын гүйцэтгэлээр нийт экспорт 16,199 сая ам.доллар, нийт импорт 9,725 сая ам.долларт хүрч тус бүр харгалзан 51.2 болон 13.8 хувиар өсжээ. Улмаар худалдааны ашиг 6,474 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс хоёр дахин өслөө.

Нийт экспортын 44 хувийг зэсийн баяжмалын экспорт, 37 хувийг чулуун нүүрсний экспортын орлого тайлбарлаж байна. Тухайлбал өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэсийн баяжмалын орлого 80 хувиар, нүүрсний орлого 52 хувиар, мөн алтны экспортын орлого 15 хувиар өсөөд байна. Харин нефтийн бүтээгдэхүүний импорт өмнөх оны мөн үеэс 22.6 хувиар өссөн нь нийт импортын өсөлтийг голлон тайлбарлаж байна.

Зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ тайлант сард 216 мянган тонн гарснаар эхний есөн сарын хуримтлагдсан дүнгээр 2,0 сая тонн хүрлээ. Мөн хилийн үнэ тонн тутамд 3,657 ам.доллар болж өмнөх сараас бага зэрэг өссөн ба өмнөх оны мөн үеэс 41 хувийн өсөлттэй байна. Цаашид цахилгаан автомашин, эрчим хүчний шилжилт, хиймэл оюун ухааны дэд бүтцийн хөрөнгө оруулалт зэрэг нь эрэлтийг дэмжих хүчин зүйлс хэвээр байна.

Чулуун нүүрсний экспортын биет хэмжээ эхний есөн сард хуримтлагдсан дүнгээр 82.2 сая тонн, сарын цэвэр дүнгээр 7.8 сая тоннд хүрчээ. Харин хилийн үнэ 83.5 $/тонн-д хүрээд байна. Экспортын өндөр хэмжээ нь БНХАУ-ын гангийн үйлдвэрлэлийн түүхий эдийн эрэлт харьцангуй тогтвортой байгаатай холбоотой байв. Тухайлбал, БНХАУ 2026 оны эхний найман сард нийт 93.6 сая тонн коксжих нүүрс импортолсон бөгөөд үүнээс Монгол Улс 53.2 сая тонн нүүрс нийлүүлж, энэ нь өмнөх оны мөн үеэс 48.8 хувиар өссөн үзүүлэлт болж байна. Улдсэн импортын хэрэгцээг ОХУ, Канад болон Австрали улсаас хангаж байна.

Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарч, төлбөрийн тэнцлийг дэмжсэнээр гадаад валютын орох урсгал сайжирч, Монгол Улсын гадаад валютын улсын албан нөөц 2026 оны 9 дугаар сарын эцэст 8.8 тэрбум ам.долларт хүрчээ. Харин төгрөгийн ам.доллартай харьцах ханш 3,596 төгрөгт хүрч, оны эхнээс 0.9 хувиар суларсан үзүүлэлттэй байна.

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

7575-1111 /1277/
eru@golomtbank.com
www.dua.golomtbank.com

Голомт банкны төв байр,
Сүхбаатарын талбай 5, Ш/х-22,
Улаанбаатар 15160, Монгол Улс
SWIFT: GLMT MNUB

АНХААРУУЛГА

Голомт банкны Эдийн засгийн судалгааны хэлтэс нь Монгол улсын макро эдийн засгийг бүхэлд нь хамарч судалдаг билээ. Энэхүү тайлан нь макро эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан болно. Энэхүү тайланд тусгагдсан агуулга, санаа нь Голомт банкны байр суурийг илэрхийлэх албагүй болно. Голомт банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэ тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах, системд хадгалах, ямар нэг хэлбэрээр дамжуулах, цахим механик хэлбэрээр хувилах, бичлэг хийхийг хориглоно.